МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

# ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

## 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 оны 12 дугаар сарын 22

## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилго: Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдварын эрсдэлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих | | | | | | | |
| *Зорилт 1. Зоонозын халдварт өвчний байгалийн голомтын тархалт, идэвхжилийг тандах хянах, хүн амын дундах тархалт, эрсдэлийн түвшин тогтоох тандалт судалгааг өргөжүүлэх* | | | | | | | |
| 1.1 | БСТ-1.5<br>Баян-Өлгий аймагт тарваган тахал өвчний тандалт судалгааг хийж, голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно. | 12,4 | - Тандалтын тайлан<br>- Идэвхтэй голомтын тоо | Баян-Өлгий аймгийн Улаанхус, Бугат, Ногооннуур (Цагааннуур тосгон) сумдын хил орчмын нутгаас 171 сорьц материал цуглуулж, шинжилгээ хийхэд идэвхтэй голомт тодорхойлогдсон. | 26 секторын 234000 га талбайг хамруулан шинжилж тарваган тахал өвчний байгалийн голомтын идэвхжилийг тогтоож, хүн амын дундах тандалт судалгааг хийж эрсдэлийг тогтоосон тайлан гарсан байна. | ОХУ-тай хамтарсан тарваган тахал өвчний тандалт судалгааны ажлыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Баян-Өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур, Бугат сумын нутагт судалгааны ажлыг улсын хилийн дагуу 100 км урттай, 60 км өргөнтэй талбайд нийт 41 сектор буюу 369000 га талбайг хамруулсан.<br>1. Судалгааны хугацаанд алтайн тарвага -35, урт сүүлт зурам-31, монгол огдой -27, алаг даага -2, барагшин- 15, мэрэгч амьтны зэм үхдэл 149, 39 гадны шимэгч, махчин шувууны гулигдас 13-г цуглуулсан.<br>2. Нийтдээ 311 сорьц материалд лабораторийн шинжилгээ хийгдсэн.<br>**Үр дүн:** Батлагдсан удирдамж, аргалчлаын дагуу тандалт судалгаагаар тарваган тахлын 12 өсгөвөр илрүүлж, 11 секторын 99000 га талбайд эпизоот идэвхитэй байгаан тогтоож ажиллаа.<br>Хүн амын дундах тандалт судалгааг зохион байгуулж, 236 асуумж авч дүгнэхэд судалгаанд оролцогчдийн мэдлэгийн түвшин 69,2%-тай буюу дунд, дадал, хандлага сайн буюу 91.6%-тай, эрсдэл түвшин 76.6% буюу өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. | 100% |
| 1.2 | БСТ-1.5<br>Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумдын нутагт тарваган | 8,5 | - Тандалтын тайлан | Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумын нийт 22 секторын 198000 | 22 секторын 198000 га талбайг хамруулан | Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумдын нутагт хийгдсэн тандалт судалгаагаар нийт 16 секторын 144000 га талбай хамруулсан. Судалгаагаар | 95% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тахал өвчний тандалт судалгааг хийж голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно. | | - Идэвхтэй голомтын тоо | га талбайд тандалт хийж 4 зүйлийн 140 амьтаны 1558 гадны шимэгч болон сэг, зэмээс нийт 1729 сорьцыг шинжилгээнд хамруулсан. | шинжилж тарваган тахал өвчний байгалийн голомтын идэвхжилийг тогтооно. | 1. Монгол тарвага (Marmota sibirica) 21, урт сүүлт зурам (Spermophilus undulatus) 64, Монгол огдой (Ochotona pallasi) 54, бор туулай (Lepus tolai) 2, хадны барагчин (Alticola argentatus) нийт 5 зүйлийн 142 амьтан олзворлож, 56 зэм үхдэл, гулгидас 19 (100) амьтны үс ноолуураас бүүрэг 441, хачиг 85 , бөөс 2, нүхний амсраас 22 бүүрэг, 8 хачиг 8 цуглуулсан.<br>2. Шинжилгээг хээрийн лаборатори болон Лавлагаа лабораторид хийж гүйцэтгэв.<br>**Үр дүн:** Автолабораторид нийт 856 сорьц хүлээн авч хурдавчилсан сорил, уламжлалт ПГУ, бх-ПГУ-ын аргаар шинжлэхэд тарваган тахал, хулгана тахал, листериоз, хуурмаг сүрьеэ, эризипелойд, ям, хуурмаг ям, пастереллёз өвчний үүсгэгчийн өвөрмөц ген, эсрэгтөрөгч тодорхойлогдоогүй. Сорьцийг зөөвөрлөн авчирч төвийн лабораторид хуурмаг сүрьеэ, ям, хуурмаг ям, листериоз, эризипелоид, пастереллёз өвчний молекул биологийн шинжилгээ хийхэд бүгд сөрөг дүнтэй. | |
| 1.3 | БСТ-1.5<br>Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Бичигтийн боомтод хийгдэх тарваган тахлын хамтарсан тандалт судалгаа хийнэ. | 7 | - Тандалтын тайлан<br>- Идэвхтэй голомтын тоо | Сүхбаатар аймгийн “Бичигт”-ийн боомт орчим тандалт судалгааг хийж, 5 сектор 45000 га талбайг хамруулж лабораторийн шинжилгээнд 5 зүйл мэрэгчийн 88 сорьц цуглуулж шинжилгээнд хамруулсан | 5 сектор 45000 га талбайг хамруулан шинжилж тарваган тахал өвчний байгалийн голомтын идэвхжилийг тогтоож, хүн амын дундах тандалт судалгааг хийж | Сүхбаатар аймгийн “Бичигт”-ийн боомт орчим БНХАУ-тай хамтарсан тандалт судалгааг 5 секторын 45000 га талбайг хамруулан хийж, нийт 67 сорьцод лабораторийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ.<br>**Үр дүн**: 49 гадны шимэгч, 5 зүйлийн 18 мэрэгчийн 18 сорьцод молекул биологийн шинжилгээ хийхэд тарваган тахал, лептоспироз, пастереллёз, тарваган тахал, хантавирус, хулгана тахал, листериоз, хуурмаг сүрьеэ, эрлихиозын халдварын өвөрмөц ген илрээгүй “сөрөг” тодорхойлогдож, зоонозын халдварын эрсдэлгүй байгааг тогтоосон. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрсдэлийг тогтооно. | Хүн амын дундах тандалт судалгаагаар Эрдэнэцагаан сумын 85 иргэнийг хамруулсан ба тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг 36% буюу дутмаг, эрдслийн түвшин 14% буюу бага эрсдэлтэй. | |
| 1.4 | БСТ-1.5<br>Дорноговь аймгийн Замын-үүд, сумын нутагт хийгдэх тарваган тахлын хамтарсан тандалт судалгаа хийнэ. | 6,8 | - Тандалтын тайлан<br>- Идэвхтэй голомтын тоо | Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт 3 секторын 27000 га талбайд тандалт судалгаа хийж лабораторийн шинжилгээний дүгнэлт гарсан. | 45000 га талбайг хамруулан шинжилж тарваган тахал өвчний байгалийн голомтын идэвхжилийг тогтоож, хүн амын дундах тандалт судалгааг хийж эрсдэлийг тогтооно | БНХАУ-тай хамтарсан тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний тандалт судалгааны ажлыг 2025 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт хийж гүйцэтгэлээ.<br>Судалгааны хугацаанд БНХАУ, Монгол улс хоёр талдаа нийт 6 секторын 54000га талбайг хамруулж ажилласан. Монгол талдаа 4 секторийн 3 төрлийн 11 зүйл мэрэгч олзворлон лабораторийн шинжилгээнд хүлээлгэн өгөв<br>**Үр дүн:** Нийт 10 сорьцод тарваган тахлын үүсгэгчийн өвөрмөц F1 эсрэгтөрөгч илрүүлэх хурдавчилсан сорилоор сөрөг тодорхойлогдсон. Молекул биологийн шинжилгээгээр 11 булингад лептоспироз, листериоз, пастереллёз, тарваган тахал, хантавирус, хулгана тахал, хуурмаг сүрьеэ, эрлихиоз өвчний үүсгэгчийн өвөрмөц ген тодорхойлогдоогүй, тарваган тахлын эпизот идэвхигүй байна.<br>Хүн амын дундах тандалт судалгааг зохион байгуулж, 138 асуумж авч дүгнэхэд судалгаанд оролцогчдийн мэдлэгийн түвшин 88% буюу сайн, хандлага, дадлын түвшин 100% сайн, эрсдэлийн түвшин 32.6% буюу бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. | 100% |
| 1.5 | БСТ-1.5<br>Архангай аймгийн Тариат сумын Өгий нуур, Завхан | 9,6 | - Тандалтын тайлан | 2024 онд Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Булган аймгийн Сайхан, | Архангай, Завхан, Хөвсгөл аймгийн зарим | Архангай аймгийн Өгийнуур сумын Өгийнуур, Эрдэнэбулган сумын Баянбулагийн гол, Тариат сумын Тэрхийн Цагааннуур, Завхан аймгийн Идэр сумын Ногоон нуур, Тэлмэн сумын Идэрийн гол, | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймгийн Идэр сумын Ногоон нуур, Тэлмэн сумын Идэрийн гол, Тэлмэн нуур, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Тунамал нуур, Бүрэнтогтох сумын Дэлгэр мөрөн, Тариалан сумын Сэлэнгэ мөрөн зэрэг газруудад шумуулаар дамжих халдварын тандалт судалгаа хийнэ. | | - Идэвхтэй голомтын тоо | Сэлэнгэ аймгийн Орхонтуул зэрэг 8 цэгт 1274 шумуул цуглуулсан.<br>Нийт шумуулын төрөл зүйл 63% Culex, 28% Aedes, 8% Anopheles эзлэж байна. | сумдын нутгын гол, ус, нуурын 8 цэгт газрыг хамруулан шумуулын төрөл, зүйлийн цуглуулга хийж, өвчний халдаржилтыг тогтоож, хүн амын дундах тандалт судалгааг хийж эрсдэлийг тогтооно. | Нөмрөг сумын Тэлмэн нуур, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Дэлгэрмөрөн, Цагаан-Уул сумын Тунамал нуур, Их-Уул сумын Сэлэнгэ мөрөн зэрэг сумдын 13 цэгт газраас 550 шумуул цуглуулан зүйлийн бүрдэл, тархалтыг тогтоож, шумуулаар дамжих халдварын молекул биологийн шинжилгээ хийсэн.<br>**Үр дүн:**<br>1. Нийт цуглуулсан шумуулын 85% нь A.cataphylla, 8% A.cyprius, 5% An.messeae, 2% C.pipens зүйл байсан. Нийт цуглуулсан шумууланд ПГУ-ын шинжилгээ хийхэд хумхаа өвчний үүсгэгч болох P.falciparum, P.vivax, P.ovale, P.malariae-ын өвөрмөц ген болон япон энцефалит, денгийн чичрэг, баруун нилийн чичрэг өвчний үүсгэгчийн өвөрмөц ген тодорхойлогдоогүй.<br>2. Ийлдэс судлалын шинжилгээний үр дүнгээр 1 сорьцод (1.3%) япон энцефалит өвчний өвөрмөц эсрэгбие IgG тодорхойлогдсон. Баруун нилийн чичрэг, Денгийн чичрэг, Крым конгийн цусархаг чичрэг, Шар чичрэг өвчний халдварын эсрэг бие тодорхойлогдоогүй.<br>3. Хүн амын тандалт судалгааны дүнгээр мэдлэгийн түвшин хангалтгүй, хандлага сул, шумуулд хазуулах эрсдэлтэй байна. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6 | БСТ-1.5<br>Төв аймгийн Батсүмбэр, Жаргалант, Борнуур сумд, Нийслэлийн СХД-ийн 21-р хорооны Жаргалант тосгоны нутагт хачигт халдварын байгалийн голомтын тандалт судалгаа хийнэ. | 2,3 | - Тандалтын тайлан<br>- Идэвхтэй голомтын тоо | 2024 онд Төв аймгийн Жаргалант, Батсүмбэр сумдын нутгаас *I.persulcatus* зүйлийн хачгийн тархалт шинээр 3 цэгт газар бүртгэсэн. Хүн амын дунд хачигт энцефалит өвчний халдварыг илрүүлсэн. | Төв аймгийн Батсүмбэр, Жаргалант сумд, нийслэлийн СХД-ийн 21-р хорооны Жаргалант тосгоны 6 цэгт газар *I.persulcatus* зүйлийн хачгийн тархалтыг шинэчлэн тогтоох, хачгаар дамжих халдваржилтыг тогтоож, хүн амын дундах тандалт судалгааг хийж эрсдэлийг тогтооно. | Төв аймгийн Батсүмбэр, Жаргалант, Борнуур сумдын нутагт 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрийг дуустал тандалт судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгааны явцад 257 хачиг цуглууллаа.<br>**Үр дүн:** Нийт 257 хачиг цуглуулснаас 92% нь *I.perculcatus*, 8% *D.nuttalli* байсан. Нэг дарцаг км 2,23% хачиг тоологдсон. I.persulcatus зүйлийн хачгийн 6.47%-д анаплазмоз, 8.6%-д хачигт риккетсиоз+ анаплазмоз+ хачигт энцефалит, 15.1%-д хачигт риккетсиоз+ анаплазмозын, 0.7%-д бабезиоз+ хачигт риккетсиоз+ хачигт энцефалит, 17.26%-д хачигт риккетсиозын, 2.15%-д хачигт энцефалит+хачигт риккетсиозын, 10.79%-д анаплазмоз+хачигт риккетсиоз+эрлихиозын; D.nuttalli зүйлийн хачгийн 62.5%-д хачигт энцефалит+ хачигт риккетсиозын, 37.5%-д анаплазмоз+ хачигт энцефалитын үүсгэгчийн өвөрмөц ДНХ хавсарсан байдлаар тодорхойлогдлоо.<br>Тандалт судалгааны явцад ойн хачгийн тархалтыг Батсүмбэр сумаас 1 цэгт, Жаргалант сумаас 2 цэгт газар шинээр тэмдэглэлээ.<br>Хүн амын дундах тандалт судалгааг зохион байгуулж, 123 асуумж авч дүгнэхэд судалгаанд оролцогчдийн мэдлэгийн түвшин 67% дунд, хандлага дадлын түвшин 26% хангалтгүй, эрсдэлийн түвшин 65% буюу дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. | 90% |
| 1.7 | БСТ-1.5<br>Хэнтий аймгийн ЗӨСТ-тэй хамтран шувууны тандалт хийнэ. | 6 | - Тандалтын тайлан<br>- Идэвхтэй голомтын тоо | Нэг удаагийн тандалтаар 11 зүйлийн 90 шувуу тоолж бүртгэсэн. | Хэнтий аймгийн Биндэр сумын Цагааннуур, Хүйтэний нууруудад шувууны зүйлийн бүрдлийг | Хэнтий аймгийн Биндэр сумын Цагааннуур, Хүйтэний нууруудад шувууны тандалт судалгааг хийж, нийт 46 зүйлийн 7925 шувуу тоолж бүртгэсэн.<br>**Үр дүн:** Хондон ангир 1235, зэрлэг нугас 1194, халзан түнжүү 1317, бор нугас 754, өвөгт тогоруу 648, алаг ээтэн 260, умардын хавтгаалж 185 тоологдсон. Нуураас 2 км зайд зусаж буй нийт 6 айлын 6 иргэнд шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоож, шувууны томуугийн халдваржилтыг тогтооно. | зөвлөмж, тараах материал өгч, асуумж судалгаа авав. Нуурын цэг тус бүр дээрээс нуурын орчны айл, мал, амьтны тоо болон экологийн бусад мэдээллийг цуглуулж, шаардлагатай хийгдэх шинжилгээний арга, амьтан, шувууны зүйлийг тодорхойлсон. | |
| 1.8 | БСТ-1.5<br>Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Буйрын гол, Цагаан элст гол, Бааст голын орчмоор “Заарт харх”-ны гельмент, хулгана тахал өвчний тандалт судалгаа хийнэ. | 3,2 | - Тандалтын тайлан<br>- Идэвхтэй голомтын тоо | Ховд аймгийн Чандмань сумын нутгаас агнасан заарт харх (Ondatra zibethicus)-ны элэгний сорьцноос цулцант бэтгийн үүсгэгч E.multilocularis-ын авгалдай илэрсэн. | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Буурын гол, Цагаан элст гол, Бааст гол, Шаамар сумын Орхон гол орчмын 4 цэгт газрыг хамруулан өвчний халдваржилтыг тогтооно. | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Буурын гол, Цагаан элст гол, Бааст гол, Шаамар сумын Орхон гол орчмын 4 цэгт газрыг хамруулсан тандалт судалгааг 45000 га талбайг хамруулан хийж гүйцэтгэтгэсэн.<br>Бааст гол, Буурын гол дагуу Хоёр элс, Цагаан шороотын нуур, авто замын гүүрийн хоёр талын цөөрөм, Орхон голд цутгах хэсэг, Охь хөндийд заарт хархны тархалтыг тогтоох ажиглалт судалгаа хийж 18 эзэнгүй овоохой, 13 эзэнтэй овоохой нийт 32 овоохой илрүүлж 48 хавхат хоног ажиллуулж, 11 заарт харх, 1 усны булга олзорлов.<br>**Үр дүн:**<br>Тандалт судалгаагаар олзворлосон 11 амьтанд 8 өвчний үүсгэгч илрүүлэх нян харах, нян судлалын шинжилгээгээр лептоспироз, хулгана тахал, хуурмаг сүрьеэ, ям, хуурмаг ям, листериоз, эризипелоид, пастереллёз өвчний үүсгэгч илрээгүй. Мөн 4 өвчний үүсгэгчийн нуклейн хүчил илрүүлэх молекул биологийн шинжилгээгээр листериоз, эризипелоид, лептоспироз, хуурмаг сүрьеэ өвчний үүсгэгчийн өвөрмөц ген тодорхойлогдоогүй. 11 амьтны 44 сорьцод бүрэн бус задалгааны аргаар гельминтийн үйланхай илрүүлэх шинжилгээ хийхэд бэтгийн үйланхай илрээгүй. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | БСТ-1.3<br>Холер, боом өвчний хяналтын шинжилгээг зохион байгуулна. | 3 | - Хяналтын шинжилгээний тайлан<br>- Сорьцын тоо<br>- Шинжилгээний тоо | Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй эрсдэлтэй 23 байгууллагын 88 цэгт газраас нийт 328 сорьц цуглуулан тархвар судлалын дүгнэлт гарсан. | 23 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан сорьц шинжилж боом өвчний эрсдэлийг тогтооно. | -Боом өвчний хяналтын шинжилгээг эрсдэл бүхий 9 аж ахуйн нэгжээс арчдас 102, үс ноос 6, нийт 108 сорьц цуглуулж нян судлалын аргаар шинжлэхэд боомын үүсгэгч илрээгүй.<br>-Холер өвчний хяналтын шинжилгээг эрсдэл бүхий 6 цэгт газраас арчдас 30, ус 4, хүнс 12 нийт 46 сорьц цуглуулж нян судлалын аргаар шинжлэхэд холер өвчний үүсгэгч илрээгүй. | 80% |
| 1.10 | БСТ-1.3<br>Монгол улсад зөөвөрлөгдөн орж ирсэн хумхаа өвчний тохиолдлын цуврал судалгаа хийнэ. | - | - Судалгааны тайлан<br>- Эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо | Хумхаагийн эрт илрүүлэг зохион байгуулж, 2024 онд 145 хүнийг хамруулсан судлагааны дүгнэлт гарсан. | 2022-2025 оны хооронд Хумхаа өвчний голомтот нутагт энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон цэргийн албан хаагчдаас шинжилгээ авч, судалгаа гаргасан байна. | Хумхаа өвчний голомтот нутагт энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон албан хаагчдаас 2023 онд 250 албан хаагч, 2024 онд 120 албан хаагчаас тус тус түргэвчилсэн тестээр сорьц авч шинэчилсэн. Дээрхи бүх сорьц сөрөг дүнтэй гарсан.<br>2025 онд Цэргийн албан хаагчдад шинжилгээ хийгдээгүй.<br>Цаашид хумаа өвчний голомтот бүс нутагт тархсан хумхаагийн үүсгэгчийн төрөл зүйлтэй холбон судлахаар төлөвлөсөн. | 100% |
| 1.11 | БСТ-1.3<br>УМЭАЦТЛ-той хамтран Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв 5 аймгийн зарим сумдад “Анзааргдаггүй өвчний (бэтэг, фасциолёз, токсоплазмоз,) халдварын тархалтыг хүн, мал | 12 | Судалгааны тайлан | 2024 онд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн 5 сумын нутаг дэвсгэрт амьдарч буй хүн, мал амьтны цуснаас авсан шинжилгээгээр Taeniidae овгийн Echinococcus (эхинококк), Toxoplasma gondii үүсгэгч, fasciola sp | Анзааргддаггүй халдварын үүсгэгч, тархалт, халдваржилтын түвшин болон завсрын эзний төрөл зүйлийн талаар судалгаа хийнэ. | Тандалт судалгаагаар 5 аймгийн 7 сумын 5-88 насны 164 хүнийг хамруулав. Шинжилгээгээр судалгаанд хамрагдсан хүн амын 14% (23/164)-д фасциолын өвөрмөц эсрэгбие IgG тус тодорхойлогдсон.<br>**Үр дүн:**<br>1. Лабораторийн шинжилгээнд тандалт судалгаагаар цуглуулсан хүний цусны 179 ийлдэс хүлээн авч анзааргддаггүй өвчний бүлэгт хамаарах бэтэг, фасциолёз өвчнийг фермент холбох урвалын аргаар шинжлэхэд фасциолёзын эсрэгбие IgG 23, бэтгийн эсрэг бие IgG 8 тус тус тодорхойлогдсон. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | амьтны дунд судлана. | | | үүсгэгчийг тодорхойлох, судлагаа хийсэн | | 2. Фасциолын халдвар эерэг гарсан малчдын дундаж нас 44.2 (5–73 насны), хүйсийн хувьд эрэгтэйчүүд 60%, эмэгтэйчүүд 40%-ийг эзэлж байв. Халдвар авсан байдлыг нас, хүйсийн байдлаар авч үзвэл 10-19 насны дунд 10%, 20-29 насны дунд 9.1%, 30-39 насны дунд 20.7%, 40-49 насны дунд 9.1%, 50-59% насны дунд 18.9%, 60 дээш насны дунд 12.1% халдварлалттай байв.<br>3. Судалгаанд хамрагдсан төвийн бүсийн аймгуудаас Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн хүн амын дунд фасциолын халдвар 14% байгаагаас Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол суманд хамгийн өндөр байна. Энэ нь Монгол орны хүн амын дунд фасциолын халдвар шинээр бүртгэгдэж байгаа нь уг халдварын эрсдэлт хүчин зүйл, дамжих замыг нарийвчлан судлах шаардлагатайг харуулж байна. | |
| 1.12 | БСТ-1.4 Зоонозын халдварт өвчний дамжуулагч шумуул, бүүрэг, хачиг тодорхойлох стандарт ажиллагааны зааврыг боловсруулна. | - | Эрүүл мэндийн сайдын тушаал | ОХУ-ын 1970-1980 онд хэвлэгдсэн бүүрэг тодорхойлох бичиг | 3 стандарт ажиллагааны зааврыг шинээр боловсруулж, батлуулна. | Хачиг, бүүрэг, Бусад шавж, шумуулын стандарт ажиллагааны заавар боловсруулан, албаны даргаар батлан, шимэгч судлалын болон гелимент судлалын лабораторид байршуулан ажиллаж байна. | 100% |
| 1.13 | БСТ-1.5: Зоонозын халдварт өвчний тохиолдол шинээр илэрсэн тохиолдолд | - | Шинээр илрүүлсэн халдварын тоо | Сүүлийн 10 жилд хумхаа, ям, бэтэг, баруун нил, денги, токсоплазмоз, лейшменоз зэрэг зоонозын халдварт | Зоонозын халдварт өвчний тохиолдол шинээр илэрсэн | Монгол улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар (салбар хооронд) 2025 онд тарваган тахал, шувууны томуу, гахайн стрептококк 3 төрлийн өвчлөлд 5 удаагийн эрсдэлийн түргэвчилсэн болон үйл явдалд суурилсан үнэлгээ зохион байгуулсан байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оношлон бүртгэсэн байна. | | | өвчнүүдийн шинэ тохиолдол, нас баралт бүртгэгдсэн. | тохиолдолд оношлон бүртгэсэн байна. | 1. Тарваган тахал өвчний эрсдэлийн үнэлгээ 3 удаа Хөвсгөл, Ховд аймагт бүртгэгдсэн сэжигтэй тохиолдолд үнэлгээ хийхэд 2 тохиолдол дунд эрсдэлтэй, 1 тохиолдол өндөр эрсдэлтэй үнэлэгдэж, эргэн мэдээлж, зөвлөмжөөр ханган ажилласан.<br>2. Улаанбаатар хот Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн Гахайн стрептококк өвчний эрсдэлийн үнэлгээ 1 удаа хийсэн бөгөөд бага эрсдэлтэй үнэлэгдэж, эргэн мэдээлж, зөвлөмжөөр ханган ажилласан.<br>3. Архангай аймгийн Өгий нуур суманд бүртгэгдсэн шувууны томуу өвчний эрсдэлийн үнэлгээ 1 удаа хийхэд дунд эрсдэлтэй үнэлэгдэж, эргэн мэдээлж, зөвлөмжөөр ханган ажилласан..<br>Тайлант хугацаанд онош тодруулахаар 608 сорьц хүлээн авч 12 төрлийн зоонозын халдварыг 6 төрлийн лабораторийн шинжилгээний аргаар шинжлэхэд нийт 110 сорьцод 5 төрлийн (хумхаа, хачигт энцефалит, риккетсиоз, бэтэг Streptococcos suis 2) өвчний үүсгэгч, эсрэгтөрөгч, эсрэгбие болон өвөрмөц ген тодорхойлогдсон. | |
| 1.14 | БСТ-1.5<br>Хүнсээр дамждаг гельминтийн тандалт судалгааг ХАБҮЛЛ- тай хамтран гүйцэтгэнэ. | 7 | Тандалт судалгааны тайлан гарсан байна. | 2020 онд хийгдсэн судалгааны дүнгээр жимс жимсгэнэ, хүнсний ногоонуудаас Strongyloides stercoralis авгалдай, Ascaris lumbricoides өндөг, Toxocara spp. өндөг, Oesophagostomum | БНХАУ-аас Монгол улсад импортоор орж ирдэг 7 төрлийн хүнсний ногоо, 6 төрлийн жимс жимсгэнээс сорьц авч гельминт илрүүлэх шинжилгээг хийнэ. | Хөрс, хүнсээр дамждаг гельминтийн тандалт судалгааны ажлыг ХАБҮЛЛ-тай хамтран гүйцэтгэв. Судалгаагаар 13 төрлийн хүнсний нарийн ногоо, 5 төрлийн жимс жимсгэнийн сорьцод гельминтийн өндөг хөвүүлэх шинжилгээ хийсэн.<br>**Үр дүн:** Шинжилгээгээр мандарины сорьцноос Strongyloides төрлийн дугираг хорхойн өндөг, цагаан гааны сорьцноос ургамлын шимэгч дугираг хорхойн өндөг, сармисны голын сорьцноос Ascaridia төрлийн дугираг хорхойн өндөг илрүүлэв. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авгалдай, Diapterobates notatus авгалдай болон өндөг илэрсэн. | | | |
| 1.15 | БСТ-1.2 Тандалт судалгааны үр дүнг Arc-GIS программ ашиглан газар зүйн зурган мэдээллийн сан үүсгэнэ. | 150 | Мэдээллийн санд оруулсан мэдээллийн тоо-9 | Arc-GIS 10.8 программ ашигладаг. Мэдээллийг үүсгэх зүйн орчин бүрдсэн. | Тандалт судалгааны үр дүнг цахимаар хүлээн авч, газар зүйн мэдээллийн сан үүсгэнэ. | 2025 онд төлөвлөсөн 8 тандалт судалгааны ажил болон мэрэгчийн дуудлагын үр дүнг QGIS программ ашиглан 9 газрын зураг хийсэн. Нийт хийгдсэн зургаар газарзүйн мэдээллийн сан үүсгэн ажиллав. | 100% |
| 1.16 | Зоонозын өвчний шимэгчийн лабораторийн оношилгоонд хиймэл оюун ухаанд суурилсан тандалтын системийг нэвтрүүлэх | 100 Төсөл хөтөлбөр | Нэвтэрүүлсэн системийн хэрэгжилтийн хувь | - | Шимэгчийн лабораторид хиймэл оюун ухаанд суурилсан системийг суулгаж, оношилгоонд нэвтрүүлсэн байна. | "Цар тахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх монгол улсын чадавхыг нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх төсөл"-ийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд оруулж зардлыг шийдвэрлүүлээд байна.<br>Хиймэл оюун ухааны машин сургалтын бэлтгэл ажлын хүрээнд тарваган тахлын бүүрэгний өндөр нягтаршил бүхий 300 ширхэг фото зургийн сан үүсгэн ажиллаж байна. | 70% |
| *Зорилт 2. Зоонозын өвчний онош зүйн лавлагаа тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх* | | | | | | | |
| 2.1 | БСТ-2.1 Төвийн лаборатори MNS ISO/IEC 17025:2018 буюу Сорил болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих | - | Нэвтрүүлэлтийн хувь | ISO 15189:2015 нэвтрүүлсэн. | Төвийн лаборатори MNS ISO/IEC 17025:2018 үе шаттайгаар нэвтрүүлсэн байна. | -2025 оны 08 дугаар сарын 06–07-ны өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төвтэй хамтран MNS ISO/IEC 17025:2018 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах шаардлага" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад тус төвийн болон Нийслэл, аймгийн 14 ЗӨСТ-ийн 60 эмч, мэргэжилтэн хамрагдаж сертификат олгосон.<br>-Зоонозын сүлжээ лабораторийг MNS ISO/IEC 17025:2018 стандарт итгэмжлүүлэхээр 20 үзүүлэлт бүхий нотлох баримт бичгийн хамт өргөдөл № 209- | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ерөнхий шаардлага стандартаар итгэмжлүүлнэ. | | | | | өөр Үндэсний итгэмжлэлийн төвийн https://eaccreditation.gov.mn/projectrequests/ цахим хаягаар хүргүүлсэн. | |
| 2.2 | Зоонозын өвчний хариу арга хэмжээ хэмжээ, хяналт, сэргийлэлтийн зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. | Зоонозын 14 өвчний хариу арга хэмжээ, хяналт, сэргийлэлтийн зааврыг шинээр батлуулан мөрдөж ажилласан байна. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 тушаалаар батлагдсан зонхилон тохиолдох зоонозын 6 халдваруудын хариу арга хэмжээ, хяналт, сэргийлэлтийн зааврыг шинэчлэх тушаалын төслийг боловсруулан хавсралтаар 14 зоонозын халдварын хариу арга хэмжээ, хяналт, сэргийлэлтийн заавар болгон өргөтгөн боловсруулж, тушаалын төслийг 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1а/604 тоот албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлээд байна. | 90% |
| 2.3 | БСТ-2.3<br>Зоонозын халдварт өвчний оношилгоо, судалгаанд үүсгэгчийн генийн дараалал тогтоох молекул биологийн шинжилгээний аргыг нэвтрүүлнэ. | - | Генийн дараалал тогтоосон сорьцын тоо | 2024 онд Тарваган тахлын сонгогдсон 80 омогт II үеийн (NGS) генийн дараалал тогтоох аргаар антибиотик тэсвэржилтийн ген, төрөл зүйлийн тархалт, мутацын судалгаа хийсэн. | Зоонозын халдварт өвчний оношилгооны 100 сорьцод генийн дараалал тогтоох шинжилгээ хийнэ. | Зоонозын халдварт өвчний оношилгоонд генийн дараалал тогтоох шинжилгээг ашиглаж эхэлсэн. 2025 онд тус төв нь дараах шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэлээ.<br>-Y. pestis 77 өсгөврийн pPCP1 плазмидыг ялган цэвэршүүлж, iseq100 системээр бүхэл плазмидын нуклеотидын дарааллыг тогтоон, стандарт лавлах дарааллуудтай харьцуулж, генетикийн ялгаа болон филогенетик уялдааг тодорхойлсон.<br>-Этүгэн их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд 27 Staphylococcus aureus өсгөврийн nucA генийг олшруулж ампликоны нуклеотидын дарааллыг тогтоон нэг нуклеотидын полиморфизмийн судалгаа хийсэн.<br>-Монгол улсад бүртгэгдсэн хүнээс ялгасан Streptococcus suis 1 өсгөвөрт халдварын бүхэл геномын дараалллыг тогтоосон. | 100% |
| 2.4 | БСТ-2.4<br>ЗӨСТ-үүдийн молекул биологийн лабораторийг үе | - | Молекул биологийн шинжилгээний тоо | 2024 онд Зоонозын халдварт өвчний оношилгооны 1425 сорьцод молекул | Зоонозын халдварт өвчний оношилгооны | Зоонозын сүлжээ лабораторид “Монгол Улсын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг нэг эрүүл мэндийн зарчимд тулгуурлан бэхжүүлэх” төслийн хүрээнд | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаттайгаар байгуулах шинжилгээний чадавхыг сайжруулна. | | | биологийн шинжилгээ хийсэн | 2200 сорьцод молекул биологийн шинжилгээ хийнэ. | молекул биологийн лабораторийн шинжилгээний чадавхийг сайжруулахаар автомат ДНХ ялгагч аппарат 8, гомогенжүүлэгч 14, ELISA reader 13, ПГУ машин 1, дулаан тогтоогуур 10, микроскоп 7, термит 9 нийлүүлэгдэж суурилуулалт, сургалт зохион байгуулсан. Тус онд Зоонозын 14 сүлжээ лабораторид 11591 сорьцод молекул биологийн шинжилгээ хийсэн. | |
| 2.5 | БСТ-2.5 Вирус судлалын лабораторийг биоаюулгүй ажиллагааны II түвшний шаардлагад нийцүүлэн үе шаттай хөгжүүлнэ. | 2,500 Төсөл хөтөлбөр | Хэрэгжилтийн хувь | 1971 онд ашиглалтад орсон, 2013 оноос хойш урсгал засвар хийгдээгүй барилгатай. | Лабораторийн засварын тендерийг зарласан, засварын ажил 20% хүрсэн байна. | Лабораторийн засварын ажлын тендерийг 2025 оны 07 дугаар 21-ний өдрөөс 08 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл зарлаж, “Интер консалтинг” ХХК шалгарсан. Тус компани нь батлагдсан зураг төслийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:<br>-2400 м2 хана, 1200 м2 шалны буулгалтын ажил хийгдэж дууссан.<br>-Цахилгаан хангамжийн ажил, хамгаалалтын хоолой хаялт хийгдэж, цахилгааны утас сувлэх ажил гүйцэтгэж байна.<br>-Салхивч хоолойн 240м2 угсралтын ажил гүйцэтгэсэн.<br>-1220 м2 тэгшилгээ хар шал цутгасан, хар шалны зүлгүүрийн ажил гүйцэтгэсэн хаалганы порем засварын ажил гүйцэтгэж байна.<br>-Гибсэн хана угсралтын ажил дууссан. Ариун цэврийн өрөөний хана таазны угсралтын ажил гүйцэтгэсэн.<br>-Цэвэр ус, бохир усны хоолойн угсралтын ажил гүйцэтгэж дууссан.<br>Одоогийн байдлаар засварын ажил 50% гүйцэтгэлтэй байна. | 100% |
| 2.6 | БСТ-2.6 Аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн лабораторийг MNS ISO 15189:2024 | 10 | Стандартын гэрчилгээ авсан ЗӨСТ-ийн тоо | 2023 онд 14салбар төвийн 166 эмч мэргэжилтэнд MNS ISO15189:2015 стандартын анхан шатны хичээл орж, | Аймаг, нийслэлийн 2 ЗӨСТ-ийн лабораторийг MNS ISO 15189:2024 | Зоонозын сүлжээ лабораторийг MNS ISO 15189:2024 шинэчилсэн стандарт итгэмжлүүлэхээр 20 үзүүлэлт бүхий нотлох баримт бичгийн хамт өргөдөл № 191-ээр Үндэсний итгэмжлэлийн төвийн https://eaccreditation.gov.mn/projectrequests/ цахим хаягаар хүргүүлсэн. | 90% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартаар итгэмжлүүлнэ. | | | бэлтгэл ажил эхэлсэн | стандартаар итгэмжлүүлнэ. | | |
| 2.7 | БСТ-2.7 Лабораторийн чанарын гадаад хяналтыг өргөжүүлнэ. | 5 | Ур чадварт хамрагдсан сорилын тоо | 2024 онд лабораторийн гадаад чанарын хяналтад нян судлал, молекжл биологийн чиглэлээр 3 удаа хамрагдаж, хангалттай үнэлэгдсэн. | Лабораторийн гадаад чанарын хяналтад 6 удаа хамрагдсан байна. | Лавлагаа лаборатори 2025 онд ур чадварын нян судлал, молекул биологийн чиглэлээр нийт 3 удаа хамрагдсан. Үүнд:<br>1. УМЭАЦТЛ-той лаборатори хоорондын харьцуулалтад Bacillus anthracis үүсгэгчээр хамрагдсан.<br>2. ХАБҮЛЛабораториос зохион байгуулдаг ур чадварын I-II ээлжийн сорилд хамрагдаж Listeria monocytogenes, Bacillus cereus, илрүүлэн “Хангалттай” үнэлгээ авсан. | 100% |
| 2.8 | БСТ-2.8 Аймаг, нийслэлийн ЗӨСТ-ийн лабораторийн чанарын гадаад хяналтад хамруулна. | 5 | Чанарын гадаад хяналтад хамрагдсан ЗӨСТ-ийн тоо | 2024 оноос эхлэн аймаг, нийслэлийн салбар ЗӨСТ-үүдийн лабораторийг гадаад чанарын хяналтад хамруулж эхэлсэн. | Аймаг, нийслэлийн 14 ЗӨСТ-ийн лабораторийг гадаад чанарын хяналтад хамруулсан байна. | Нийслэл, аймаг ЗӨСТ-ийн 14 салбар лабораторит 2025 онд ХАБҮЛЛабораториос зохион байгуулдаг ур чадварын I-II ээлжийн сорилд хамрагдаж Listeria monocytogenes, Bacillus cereus, Staphylococcus aurius илрүүлэн “Хангалттай” үнэлгээ авсан. | 100% |
| 2.9 | БСТ-2.9 Төвийн лабораторийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлнэ. | 35 | Хэрэгжилтийн хувь | Лабораторийн шинжилгээнд орсон 588 сорьцыг лабораторийн үндсэн бүртгэл болох Excel программд бүртгэсэн. | Лабораторийн шинжилгээний хариуг E-health үндэсний цахим системд оруулдаг болсон байна. | Лабораторийн бүртгэлийг цахим системд шилжүүлэх ажлын хүрээнд зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн дуудлагыг бүртгэл, тархвар судалгааны бүрэлдэхүүн, лабораторийн шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийн хөгжүүлэлтийг хийж, туршилтын болон нэмэлт хөгжүүлэлтийн шатандаа явж байна. Хүний өвчлөлийн дуудлага, лабораторийн шинжилгээний бүртгэлтэй холбоотой бүх АШБМ-ын мэдээллүүдийг шинээр хөгжүүлж буй цахим системд оруулах, системээс гарах тайлангийн загвар, бүрдэлийг боловсруулах ажлууд хийгдсэн. Туршилт болон нэмэлт хөгжүүлэлтийн шат хийгдсэний дараа төрийн мэдээллийн хур систем болон нийгмийн даатгалын сантай холбох зөвшөөрөл авах, холболтыг хийх ажлууд хийгдэнэ. | 95% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.10 | ISO9001:2015 Чанарын удирдлагын стандартыг итгэмжлүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, үе шаттай хэрэгжүүлнэ. | 150 Төсөл хөтөлбөр | Хэрэгжилтийн хувь | - | Чанарын удирдлагын стандартаар итгэмжлүүлэх хүсэлтээ өгсөн байна. | Чанарын удирлагын тогтолцоог хэрэгжүүлэх байгууллага болох зорилтын хүрээнд АМУ консалтинг ХХК-тай гэрээ байгуулан нийт ажилтнуудад 4 бүлэг 10 модуль бүхий чанарын удирлага, менежментийн сургалтад хамруулсан. Тус үйл ажиллагатай холбоотой чанарын удирлагын тогтолцоонд ашиглагдах албан журам, хөтөлбөр төлөвлөгөөг шинчлэн боловсруулж ажиллаж байна.<br>Үүнд:<br>- ЭМС-ийн А/566 хоёрдугаар хавсралт, А/112 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөх “Тохиолдол, эрсдэл бүртгэх хариу арга хэмжээний журам”<br>- Ижил мэргэжилтний үнэлгээ<br>-Сэтгэл хамнамжийн судалгаа авах журам зэргийг шинчлэн батлуулсан.<br>Мөн Эйч Ар консалтинг компанитай хамтран удирдах түвшний ажилтнуудад 7 удаагийн сургалтыг зохион байгууллаа.<br>ISO9001:2015 Чанарын удирдлагын стандартыг итгэмжлүүлэх ажлын хэсгийн тайлан нэгтгэн хүсэлтээ өгөх бэлтгэл ажил хангагдаад байна. | 90% |
| 2.11 | Төвийн хэмжээнд хөтлөгддөг анхан шатны бүртгэл маягтыг шинэчлэн боловсруулна | 50 | Төвийн захирлын тушаал | 2002 оноос хойш үе шаттайгаар шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан | АШБМ-ыг боловсруулж, батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | ЗӨСҮТ, ЗӨСТ-д хөтлөгдөх АШБМ-ыг төвийн захирлын 2025 оны А/58 дугаар тушаалаар батлуулж, 86 төрлийн АШБМ-ыг 3000 хувь хэвлүүлж төвийн болон Нийслэл, аймгийн ЗӨСТ-ийн хэрэглээнд нэвтрүүлсэн. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.12 | БСТ-2.10 Эрүүл мэндийн салбарын программ хангамжуудыг интеграц хийх, модулийн нэмэлт хөгжүүлэлт хийнэ | 35 | Хэрэгжилтийн хувь | ZIS программ хэрэглээнд нэвтрүүлэн ашигладаг. | Эрүүл мэндийн салбарын бусад цахим системүүдтэй холбох ажлыг хийж гүйцэтгэнэ. | Зоонозын мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлыг METEX ХХК –тай гэрээ хийж, хамтран ажиллаж байна. Уг ажлын хүрээнд эхний модул болох төвийн лабораторийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, зоонозын хүний өвчлөлийн бүртгэл мэдээллийн системийг нэвтрүүлэх ажил 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Төрийн мэдээллийн хур системтэй холбохоор бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай хөгжүүлэлт, бичиг баримтуудыг бэлтгэж байна. | 80% |
| *Зорилт 3. Био үйлдвэрлэлийг хөгжүүлэх* | | | | | | | |
| 3.1 | БСТ-3.1 Микробиологийн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авна. | 10 | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ | Тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэл үйлдвэрлэх тусга зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг хангах бэлтгэл ажил 25%-тай хийгдсэн байна. | Тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг хангах бэлтгэл ажил 50%-тай хийгдсэн байна. | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх “ТЭЖЭЭЛТ ОРЧИН БИОБЭЛДМЭЛИЙН ҮЙЛДВЭР ТӨСӨЛ”-ийг холбогдох хууль журмын дагуу боловсруулж, төвийн Удирдлагын зөвлөлийн 2025 оны 041 дүгээр сарын 23-ны өдрийн 7 дугаар хурлаар хэлэлцэн дэмжигдсэн. БҮЛ бүрэн засварт орсонтой холбоотойгоор төслийг Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт илгээх ажил түр хойшлогдсон. | 50% |
| 3.2 | БСТ-3.3 Тэжээлт орчны үйлдвэрлэлд тоосруулан хуурайшуулах технологийг нэвтрүүлнэ. | 10 | Хэрэгжилтийн хувь | /-/ | Мэргэжилтнүүдийг үе шаттай сургалтуудад хамруулна. | Орон нутгийн нян судлаач, лаборант нарт хуурайшуулсан тэжээлт орчин хэрхэн хэрэглэх талаар цахим хурлыг зохион байгуулсан. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | БСТ-3.4 Зоонозын халдварт өвчний оношилгооны хурдавчилсан тестийг туршилтаар үйлдвэрлэнэ. | - | Батлагдсан арга зүй | Бруцеллёзын розебенгалын урвалын оношлуурыг туршилтаар үйлдвэрлэх судалгаа хийж байсан. | Судалгааны арга зүй батлагдсан байна. | Тарваган тахлын вакцины EV омгийн ашиглан бүрээсийн (F1) эсрэгтөрөгчийг ялгах, хэт дархан ийлдэс гаргаж авах туршилтын ажлын удирдамж" боловсруулан, Төвийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | 80% |
| 3.4 | "Зоонозын өвчин судлалын ариутгал, халдваргүйтгэл, био үйлдвэрлэлийн лаборатори" төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-аар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах, дүгнүүлнэ. | 8 | – Батлагдсан төлөвлөгөө<br>– Төлөвлөгөө-ний хэрэг-жилтийн хувь | Төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-аар хянуулан, батлуулж, төлөвлөгөөний биелэлт 94,7%-тай дүгнэгдсэн. | 2025 онд төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангаж дүгнүүлсэн байна. | "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2025" –ыг боловсруулан, БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх батласан. Төлөвлөгөөний биелэлтийн тайланг холбогдох материалуудын хамт БОУАӨЯ-ны цахим флатформоор хугацаанд нь илгээсэн. | 100% |
| *Зорилт 4. Ариутгал, халдваргүйжүүлэлт, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх* | | | | | | | |
| 4.1 | Ариутгал, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжүүдийг бүрэн автоматжуулна. | 21 ОХУ-ын санхүүжилт | Хэрэгжилтийн хувь | Давтан хэрэглэгддэг шил, савыг гар аргаар угааж, хатаах шүүгээнд хатааж, автоклавт ариутгадаг. | Ариутгал, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжийг 50 хувийг автоматжуулна. | 2026 оны захиалганд Багаж хэрэгсэл угаалгын автомат машин, ариутгалын бүрэн хатаалгатай автоклав захиалсан.<br>2025 онд ариутгал халдваргүйтгэл биоүйлдвэрлэлийн хэсэгт хатаах шүүгээ-2ш, кварцын гэрэл-11ш, тертостат-3ш сэгсрэгчтэй термостат-1ш нийт 19 тоног төхөөрөмж багаж хэрэгслийг шинэчлэн ажиллаж байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2 | Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | - | Гэрээ хийсэн байгууллагын тоо | 2024 онд 2 байгууллагатай халдавргүйтгэл, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэлийн гэрээ байгуулан ажилласан. | 2025 онд 5 байгууллагатай халдавргүйтгэл, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэлийн гэрээ байгуулан хамтран ажиллана. | 5 байгууллагатай гэрээ байгуулан ажилласан ба нийт 10800 м2 талбайд ахуйн шавж, мэрэгч устгал, урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийн ажил хийсэн. Үүнд:<br>1.“Ноён пицца” ХХК-ны 1300 талбайд мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэл, халдваргүйжүүлэлт<br>2.Жаргалант сувилалын 3500 м2 талбайд мэрэгчгүйтгэл, халдваргүйжүүлэлт<br>3. Дотоодын цэргийн 05 дугаар ангийн 4000 м2 талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт<br>4. Хилийн цэргийн 151 дүгээр цэргийн ангид 3319 м2 мэрэгчгүйтгэл, халдваргүйжүүлэлт<br>5. Онцгой байдлын ерөнхий газрын 4443 м2 талбайд шавжгүйтгэл<br>6. Эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахад 4 удаа нийт 2000 м2 талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт тус тус хийж гүйцэтгэсэн. | 100% |
| *Зорилт 5. Хүн амыг зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх* | | | | | | | |
| 5.1 | БСТ-5.1<br>Зоонозын халдварт өвчнөөр сэдэвчилсэн бие дааж сурах цахим хичээлийн контент боловсруулж, түгээнэ. | - | Цахим хичээлийн тоо | 2024 онд 13 цахим хичээлийн зонтент боловсруулан нийтэд хүргэсэн. | Цахим хичээлийг чанартай, хүртээмжтэй болгосон байна. | Төвийн www.nczd.gov.mn цахим хуудасны Цахим хичээл буланд Зоонозын халдварт өвчний чиглэлээр 8 контент шинээр боловсруулан нийтэлсэн. Тус буланд нийт 21 цахим хичээл орсон бөгөөд иргэд ямар ч үед хүссэн газраасаа цахимаар хандаж судлах боломжтой байдлаар нээлттэй байдлаар байршуулан түгээсэн.<br>Байгууллагын фэйсбүүк хуудсанд 791000 хүн, цахим хуудсанд 378000 хүн тус тус хандсан үзүүлэлттэй байв. | 100% |
| 5.2 | БСТ-5.2<br>Иргэдийн зан үйлд нөлөөлөх арга хэмжээний төлөвлөгөө | - | Хэрэгжилтийн хувь | 2024 онд зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудас 203 мэдээ нийтэлсэн. Нийт | Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, | Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан**,** 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>**Танхимын сургалт** | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, хэрэгжүүлнэ. | | | хандалт 186670 байна. | сурталчилгаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан, батлуулсан байна. | 1. ГЕГ-ын харьяа хилийн боомт газруудын хилийн хорио цээрийн албаны 60 байцаагчид тарваган тахал өвчний нөхцөл байдал, хил орчмын тандалт судалгааны талаар мэдээлэл хүргүүлэв.<br>2.ЦЕГ-ын замын цагдаагийн газрын 100 албан хаагчдад Зоонозын халдварт өвчний төлөв байдал, тарваган тахлаас урьдчилан сэргийлэх танхимын болон онлайнаар сургалт зохион байгуулсан.<br>3. Монголын улаан загалмай нийгэмлэгийн Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын газар “Гамшиг, онцгой байдлын үеийн нийгмийн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг 11 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд Хүүхэд залуучуудын хөгжлийн төвд зохион байгуулж байна. Сургалтад 21 аймаг, 9 дүүргийн Дунд шатны хорооны арга зүйч, сайн дурын 80 гаруй идэвхтнүүд хамрагдсан.<br>4.Дотоодын цэргийн 05 дугаар ангийн 12 албан хаагчдад Зоонозын халдварт өвчний эрсдэл, нөхцөл байдлын талаар мэдээлэл хийсэн.<br>**Цахим сүлжээ:**<br>Байгууллагын цахим хуудсанд 170 мэдээ нийтэлсэн бөгөөд хандалтын тоо 791000 байна. Тарваган тахал, хачигт халдвар, галзуу, боом, бруцеллёз, бэтэг өвчнүүдээс сэргийлэх, эрсдэлд өртсөн үед авах арга хэмжээ болон гамшгийн үеийн буюу үерийн үед зоонозын халдвараас сэргийлэх мэдээ мэдээллийг нийгмийн сүлжээнд байршуулан, хүргэж байна. Төвийн фэйсбүүк хуудасны чатбот 24/7 горимоор ажиллан 71 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.<br>**Телевизийн ярилцлага:**<br>Eagle, ETV, Өлзий тв, Сүлд тв, Монгол тв, TV25, ЭМЯ-ны цахим хуудас, МҮОНТВ-д бруцеллёз, хачгаар дамжих халдвар, боом, тарваган тахал өвчний нөхцөл байдлын болон урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл 10 удаа хийсэн байна. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Мэдээллийн сайт:** Манд.мн, ubn.mn, zindaa.mn, gogo.mn, ergelt.mn, eagle.mn, eguur.mn, itoim.mn, News.mn, Ikon.mn, Isee.mn, Montsame.mn зэрэг мэдээллийн сайтуудад нийт 21 удаагийн ярилцлага, мэдээлэл өгсөн. **Шинээр боловсруулсан инфографик, постер:** Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нийт 12 ш контент шинээр боловсруулан цахим мэдээллийн хэрэгслээр ард иргэдэд мэдээлэл хүргэсэн. | |
| 5.3 | БСТ-5.3 Зоонозын өвчний үеийн эрсдэлийн харилцааны чиглэлээр тактик боловсруулна. | 5 | Эрсдлийн үнэлгээний тоо Авсан хариу арга хэмжээний тайлан | 2024 онд зоонозын өвчний сэжигтэй 5 тохиолдолд эрсдлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан. | Кристалл сургалт зохион байгуулна | -Epic төслийн хүрээнд “Дэлхийн зөн ОУБ”-тай хамтран ЗӨСҮТ–н мэргэжилтнүүд, Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгуудын салбар дундын мэргэжилтнүүдийг оролцуулсан зоонозын халдварын үеийн эрсдэлийн үеийн харилцаа холбооны чиглэлээр 3 өдрийн ширээний дасгал сургуулилт зохион байгууллаа.<br>-Хөвсгөл аймгийн Мөрөн, Цагаан уул суманд бүртгэгдсэн тарваган тахлын тохиолдол дээр байгууллагын нийт мэргэжлийн албадын мэргэжилтнүүдийг хамруулсан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж эрсдэлийн үеийн харилцаа холбооны тактик боловсруулсан. | 100% |
| 5.4 | Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлтийн эмхэтгэлийг эрхлэн гаргана. | 10 | Эрүүл мэндийн үзүүлэлтийн эмхэтгэл | “Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлт” эргэн мэдээллийг жил бүр эрхлэн гаргадаг. | 2024 оны зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, “Эрүүл мэндийн үзүүлэлт 2024” эрхлэн гаргаж, орон нутгийн ЗӨСТ-д | 2024 оны үйл ажиллгааны үндсэн үзүүлэлтээр “Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлт №20” дугаарыг эрхлэн гаргасан байна. Энэ удаагийн эмхэтгэл нь нийт 4 бүлэг 37 хүснэгт, 11 зураг, 43 графикаар илэрхийлэн зоонозын халдварт өвчний статистик мэдээллийг агуулсан.<br>“Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэл 2024”-ийг нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдэд хүргүүлсэн. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүргэгдсэн байна. | | |
| 5.5 | Эрсдэлт бүлгийн хүн амд зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтыг оновчтой зохион байгуулна. | 50 | Дархлаажуулал-тад хамрагдсан хүний тоо | 2024 онд Тарваган тахлын эсрэг дархлаажуулалт 18998 хүнийг, хачигт энцефалит өвчний эсрэг дархлаажуулалт 3954 хүнийг, галзуу өвчний сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан галзуугийн вакцин 8310 хүнийг тус тус хамруулсан. | Зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтыг голомтод бүс нутагт зохион байгуулна. | -Тайлант хугацаанд Хачигт энцефалитын дархлаажуулалтад 16 аймгийн 50 сум, Нийслэлийн 8 дүүргийн нийт 3833 хүн хамрагдсан. Үүнээс голомтот нутгийн хүн ам 27%, ЭМБ-ын ажилчид 0.7%, Онцгой байдлын албан хаагчид 19.5%-ийг эзэлж байна.<br>-Галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан 6459 хүн галзуу өвчний эсрэг вакцинд хамрагдсан. Үүнээс өндөр эрсдэлтэй 37 хүн галзуугийн эсрэг иммуноглобулин эмчилгээнд хамрагдсан | 100% |
| *Зорилт 6. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авах хариу арга хэмжээний бэлэн байдал, чадавхыг сайжруулах* | | | | | | | |
| 6.1 | БСТ-6.1<br>Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ. | 2,000 | Нөөцийн хэмжээ | ЭМС-ын 2023 оны А/211 дүгээр тушаалын дагуу улсын хэмжээний эрүүл мэндийн салбарын нөөцийг хангаж ажилладаг. | Улсын хэмжээний эрүүл мэндийн салбарын нөөцийн бэлэн байдлыг хангаж, татан авалт хийн байршуулсан байна | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 Жагсаалт батлах тухай тушаалаар Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн тоо хэмжээг баталсан.<br>ДЭМБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх үндэсний ЕМТ багийн хэрэглэх иж бүрдэл 111 нэр төрлийн 1.2 тэрбум төгрөгийн хүч хэрэгслийг хүлээлгэн өгсөн бөгөөд эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахад зориулалтын дагуу төрөлжүүлэн бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. | 100% |
| 6.2 | БСТ-6.2<br>Зоонозын халдварт өвчний аюул, эрсдэлийн үед ажиллах тохиолдлын | - | Төвийн захирлын тушаал- 1 . 2025.11.19. А/72 тоот тушшаал | 2024 онд зоонозын өвчний сэжигтэй 5 тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл, | Мэргэжлийн багийн журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан эрсдэлийн | Төвийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/72 тоот тушаалаар “Зоонозын халдвар хариуцсан баг”-ийн ажиллах тухай журам батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагын тогтолцооны багуудын бэлэн байдал, чадавхыг бэхжүүлнэ | | | зөвлөмжөөр ханган ажилласан. | бэлэн байдлыг хангаж ажиллана. | | |
| 6.3 | БСТ-6.3<br>Нэг эрүүл мэнд салбар хоорондын зөвлөлийн тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлнэ. | 50 Төсөл хөтөлбөр | Уулзалтад оролцсон байгууллага, оролцогчдын тоо | “Нэг эрүүл мэнд-зооноз” сэдэвт үндэсний эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан. | “Нэг эрүүл мэнд” үндэсний зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байна. | Монгол Улсын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн удирдлага, зохион байгуулалтын шуурхай байдал, нотолгоонд суурилсан мэдээлэл-судалгааны нэгдсэн удирдлагын нэгжийг бий болгох хүрээнд УОК-ын даргын 2025 оны 02 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг ажиллалаа. Үүнд:<br>1. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 4 бүлэгт хувааж, багийн ахлагч томилон үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.<br>2. Багийн бүрэлдэхүүн бүтнээр болон хэсэгчилсэн байдлаар 15 удаагийн ажлын хэсгийн уулзалт, хурлыг зохион байгуулж ажилласан.<br>3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дараах чиг үүргийн хүрээнд ажилласан. Үүнд:<br>3.1. Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалыг шинэчлэх<br>3.2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний үнэлгээний зөвлөмжийг нэгтгэх.<br>3.3. Стратегийн эрсдэлийн зураглал боловсруулах<br>3.4. Монгол Улсын эрүүл мэндийн аюулгүй байдлын төлөвлөгөөний төсөл боловсруулах.<br>Үндэсний хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 27–28-нд зохион байгуулж, хэлэлцүүлэгт аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмч мэргэжилтэн, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөл нийт 80 гаруй мэргэжилтэн оролцлоо. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.4 | Эрүүл мэндийн салбарын Гамшиг ноцтой үеийн бэлэн байдлын дадлага сургуулилт зохион байгуулна. | 150 | Арга хэмжээний тайлан-1 | - | Эрүүл мэндийн салбарын гамшиг, ноцтой үеийн бэлэн байдлын дадлага сургуулилалт зохион байгуулна. | ЭМС-ын 2025 оны А/151 тоот тушаалаар “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ гамшгийн үзүүлэх сургалт”-ыг зохион байгууллаа. Тус үзүүлэх сургалтад ЭМЯ, НҮБ, Дэлхийн банк, МУЗН, ОБЕГ, УНТЭ, ХӨСҮТ, УХТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ, ЦТЭ болон аймаг нийслэлийн 14 ЗӨСТ-ийн нийт 295 албан хаагч оролцов. НЭМ-ийн ноцтой байдал бүртгэгдсэн үеийн хариу арга хэмжээ сэдвээр цагийн байдал өгч, хээрийн эмнэлэг дэлгэж үзүүлэн, хариу арга хэмжээг зохион байгуулан олон улсын жишигт нийцүүлэн дадлага сургуулилтыг зохион байгууллаа. | 100% |
| *Зорилт 7. Зоонозын салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах* | | | | | | | |
| 7.1 | БСТ-7.1 “Зоонозын өвчин судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулна. | /-/ | Эмнэлзүйн батлагдсан хөтөлбөр | Тус төв нь “Зоонозын өвчин судлал” үндсэн мэргэшлийн сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулдаг. | Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна. | Эрүүл мэндийн салбарын эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр, чиглэл, индексийг шинэчлэн батлах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын тушаал гарсантай холбоотой “Зоонозын өвчин судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулах ажлыг хойшлуулсан. Тус ажлын хэсгийн уулзалтад төвийн захирал 1 удаа, сургалт, эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн албаны дарга 1 удаа тус тус оролцож “Зоонозын өвчин судлал” үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, хөтөлбөрийг хэрхэн шинэчлэх талаар саналаа оруулсан. Мөн Эрүүл мэндийн хөгжлийн төвд үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекст оруулах саналаа цахимаар хүргүүлж ажиллаа. | 90% |
| 7.2 | БСТ-7.2 Зоонозын өвчин судлалын тэргүүлэх чиглэлээр мэргэжилтнүүдийг | 100 Төсөл хөтөлбөр | Хамрагдсан мэргэжилтний тоо | 2024 онд нийт ажилтан, албан хаагчдын 34 хувийг гадаад, дотоодын | Гадаадын сургалтад хамрагдах мэргэжилтнүүдийн тоог | 2025 онд тус төвөөс Австрали, ОХУ, Япон, БНХАУ, Малайз, Сингапур, Пакистан зэрэг гадаадын өндөр хөгжилтэй орнуудад Зоонозын өвчин судлалын тэргүүлэх чиглэлээр 8 удаагийн сургалтад 45 мэргэжилтэн хамрагдсан байна. Энэ нь нийт | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гадаад улсад сургалтад хамруулна. | | | сургалтад хамруулсан. | нэмэгдүүлсэн байна. | мэргэжилтнүүдийн 45 хувь буюу өмнөх жилийн үзүүлэлтээс нэмэгдсэн үр дүнтэй байна. | |
| *Зорилт 8. Зоонозын халдварт өвчний эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх* | | | | | | | |
| 8.1 | БСТ-8.1 Зоонозын өвчний эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэх тодорхойлно. | 150 | Төвийн захирлын тушаал | Төвийн захирлын 2016 оны А/83 дугаар тушаалаар батлагдсан Зоонозын өвчний эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэл 2016-2020 онд бүрэн хэрэгжсэн. | Зоонозын өвчний тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь зөвөлгөөнийг зохион байгуулан захирлаар тушаалаар баталгаажуулна. | Монгол улсын хэмжээнд зоонозын тэргүүлэх өвчний жагсаалтыг тодорхойлох хэлэлцүүлгийг 2025 оны 04 сарын 25-ны өдрийн А/24 тоот тушаалаар баталж ДЭМБ-ын санхүүжүүлэлттэй зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагаанд Ховд, Увс, Говь-Алтай, Баян-Өлгий, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ, Завхан, Дундговь, Өмнөговь аймаг, Нийслэлийн зоонозын өвчин судлалын төв, Зоонозын өвчин судлалын Үндэсний төвийн эмч, ажилтан нийт 117 хүн оролцов. | 100% |
| 8.2 | БСТ-8.2 “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн 2025 оны заасан дугаарыг эрхлэн гаргана. | 50 | Хэвлүүлсэн өгүүллийн тоо | Тус төв нь “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн 2024 оны 5 дугаарыг эрхлэн гаргасан. | “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийг хэвлүүлэхэд хамтран ажиллаж, сэтгүүл хэвлүүлсэн байна | “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн 2025 оны V (124) дугаарыг эрхлэн боловсруулж, олны хүртээл болгов. Зоонозын өвчин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл 3, хэвлэлийн тойм 1, эпоним 1 материал тус тус судлаачдаас авч, сэтгүүлийн редакциар гишүүдээр хянуулж нийтлүүлэв. | 100% |
| 8.3 | ОХУ-ын Эрхүү хот дахь Сибирь алс Дорнодын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэнд | - | Судалгааны үр дүн | - | Туршилт судалгааны үр дүн гарч илтгэл хэвлүүлсэн байна. | -ОХУ-тай хамтран ажиллах гэрээнд тусгагдсан тарваган тахлын оношилгооны бактеиофагуудад харьцуулсан судалгаа хийх ажлын удирдамжийг боловсруулан, төвийн захирлаар батлуулсан.<br>Удирдамжийн дагуу туршилт судалгааны ажлыг хийж, Шингэн фаг үйлдвэрлэх технологиор тэтгэн шалгахад үйлдвэрлэлийн дараах өвөрмөц чанар хэвийн, таньц | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэсэн тарваган тахлын нян залгиурт харьцуулсан судалгаа хийнэ. | | | | | Аппельманы аргаар : 0.5x10-10, Грациагаар: 0.2x10-11 байсан ба ЭЗЧХЛ-т шалгуулж тэнцсэн үр дүнг Yersinia-15 ОУЭШХ-д “Тарваган тахлын оношилгоонд хэрэглэгдэж буй нутгийн омгийн нян залгиурыг L-413 төрлийн нян залгиуртай харьцуулан судалсан дүн” сэдэвт судалгааны ажлыг хэлэлцүүлсэн. | |
| 8.4 | “Зоонозын өвчний тулгамдсан асуудал” ОУ-ын эрдэм шинжилгээ 26 дугаар хурал, “Yersinia” ОУ-ын эрдэм шинжилгээний 15 дугаар хурлыг зохион байгуулна. | 200 | Хурал зохион байгуулсан тайлан | “Зоонозын өвчний тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2 жил тутамд зохион байгуулдаг. | “Зоонозын өвчний тулгамдсан асуудал”, “Yersinia” Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган, хурлыг зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/165 дугаар тушаалаар “Yersinia-15” олон улсын эрдэм шинжилгээний хурал, төвийн захирлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн а/16 дугаар тушаалаар “Зоонозын халдварын тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус тус баталж, 2025 оны 09 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>“Yersinia-15” олон улсын симпиозумд 4 тивийн 11 улс, Монгол улсын 5 байгууллагын эрдэмтэн судлаачдын 66 судалгааны бүтээл ирүүлсэн бол “Зоонозын тулгамдсан асуудал” олон улсын хуралд олон улсын эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 39 судалгааны бүтээлээс 12 илтгэлийг амаар, ханын илтгэл 20 гаруйг тус тус хэлэлцүүлсэн. | 100% |
| *Зорилт 9. Төвийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, хүний нөөц, төсөв, санхүү, технологийн болон бусад нөөцийг үр ашигтай удирдан зохион байгуулах* | | | | | | | |
| 9.1 | БСТ-9.2<br>Төвийн үйл ажиллагааг цахим системд шилжүүлэх, хяналтын тогтолцоог бэхжүүлнэ. | 35 | Хэрэгжилтийн хувь | 2022 оноос эхлэн зоонозын мэдээллийн систем ZIS программд өвчлөлийн мэдээллийг бүртгэж байна. | Хүний өвчлөлийн мэдээллийн системийн хөгжүүлэлтийг нэвтрүүлсэн байна. | 1. Улсын хэмжээнд 2025 онд бүртгэгдсэн Зоонозын өвчний сэжигтэй хүний болон амьтаны дуудлага, хүний өвчлөл, нас баралтын мэдээг сар бүр нэгтгэн гаргаж, ZIS мэдээллийн сантай тулган, баталгаажуулж ЭМХТ-д 12 удаа албан тоотоор хүргүүлэн ажилласан.<br>2. Төв нь 2024 оноос Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн /ERP/ системийг нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 онд уг системийн албан бичиг, цаг бүртгэлийн модулийг бүрэн нэвтрүүлсэн. Түүнчилэн Төрийн байгууллагуудын дотоод үйл | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/, албан бичиг солилцооны дундын систем /docx/-ийн сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр танхимаар зохион байгуулан, сургалтад 46 албан хаагч хамрагдаж, албан бичиг солилцооны дундын систем ашиглан албан бичиг хүлээн авах, баталгаажуулах болон төрийн байгууллагуудын дотоод удирдлагын ERP E-Mongolia нэгдсэн систем, албан бичиг солилцооны дундын систем /docx/-ийн ашиглах мэдлэг чадварт суралцсан. | |
| 9.2 | БСТ-9.3<br>Төвийн нийгмийн хамгааллын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлнэ | - | Хэрэгжилтийн хувь | 2023 онд эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлж тайлагнасан. | Нийгмийн хамгааллын төлөвлгөөг батлуулан хэрэгжүүлсэн байна. | 2025 онд төвийн эмч, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах 19 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 100 хувь биелүүлэн ажилласан. | 100% |
| 9.3 | БСТ-9.4<br>Зоонозын халдварт өвчний тусламж үйлчилгээнд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн чанар сайжруулах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулна. | - | Хэрэгжилтийн хувь | 2024 онд 48 арга хэмжээ төлөвлөснөөс 98 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн. | Төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэн ажиллана | Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд 11 удаагийн хяналт хийх хуваарийг боловсруулан, батлуулж хэрэгжилтийг хангаан ажилласан.<br>1. Зөвлөмж Ариутгал халдваргүйтгэл биоүйлдвэрлэлийн албанд -4, Лавлагаа лабораторийн албанд - 1, Санхүү хангамж нөөцийн албанд-1 нийт 6 хугацатай зөвлөмжийг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан болон эргэн хяналтыг хийсэн.<br>2. Байгууллагын ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг албан хаагчдаас санал авч, өгсөн саналын дагуу асуумжийг шинэчлэн боловсруулж батлуулан 8 бүлэгтэй 37 асуумжаар Google Forms программ ашиглан сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч дүнг нэгтгэн | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удирдлагын зөвлөлд танилцуулан ажилласан.<br>3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи, чанарын шаардлага"-ыг ханган ЭМС-ын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/260 тоот тушаалаар 2 жилийн хугацаатай Магадлан итгэмжлэл сунгагдсан.<br>4. Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн Чанарын өдөрлөг зохион байгуулсан. Чанарын өдөрлөгт 65 ажилтан хамрагдсан. Чанарыг өдөрлөгийг зохион байгуулахдаа 3 зорилтын хүрээнд зохион байгуулсан. | |
| *Зорилт 10. Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах* | | | | | | | |
| 10.1 | БСТ-10.1<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөөний й хэрэгжилтийн хувь | 2024 онд төлөвлөгөө боловсруулан 100% хэрэгжүүлсэн. | Төлөвлөгөө гарган, 100% хэрэгжүүлсэн байна. | Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн Авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг төвийн захирлаар батлуулан, хэрэгжилтийн ханган ажилласан.<br>1. Тус төвөөс авилга, ашиг сонирхолоос ангид байх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд АТГ-тай хамтарсан сургалт зохион байгуулж, 44 хүн оролцсон.<br>2. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентууд 4 байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал суваг, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэрэгт байшуулсан.<br>3. Зоонозын салбарын Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр салбарын онцлог үйл ажиллагааны улмаас авлига, ашиг сонирхлын ямар зөрчил үүсч болох, түүнээс хархэн урьдчилан сэргийлэх талаар Үндэсний төвийн болон орон нутгийн Зоонозын өвчин | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судлалын төвийн удирдлагууд хэлэлцүүлэг хийж, ямар эрсдэл үүсч болзошгүйг тодорхойлон, цаашид нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад мэдээлэл хүргэж, урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллах чиглэл өглөө.<br>Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааны 5 бүлэг бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн. | |
| 10.2 | БСТ-10.2<br>Аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт шинжилгээ үнэлгээ хийн, тайлагнана. | - | Тайлангийн тоо | Аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ээр 4.50 оноотой үнэлэгдсэн. | Аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт үнэлгээ хийнэ. | Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд үнэлгээ хийн, нэгдсэн дүнг УЗХ-р хэлэлцүүлэн, УАЗ-нд илтгэл тавьж танилцуулсан. Нийслэл, аймгийн 14 ЗӨСТ-үүдэд “Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж”-ийг боловсруулан хүргүүлсэн. | 100% |
| 10.3 | Төвийн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд Кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэнэ. | - | Эрсдлийн үнэлгээний дүн | - | Төвийн системийн кибер аюулгүй байдлын эрдслийн үнэлгээг хийлгэнэ. | 2025 оны 8 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд ТЕГ-ын Мэдээллийн аюулгүй байдлын газрын 3 ажилтны бүрэлдэхүүнтэй баг ЗӨСҮТ-ийн мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дүрэм, журам, төлөвлөлт, мэдээллийн систем, сүлжээ, серверийн өрөөний болон орчны аюулгүй байдалд кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийж зөвлөмж дүгнэлт өгсөн. Өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцооны хүрээнд хэрэгжүүлэн биелэлтийг заасан хугацаанд Мэдээллийн аюулгүй байдлын газарт албан тоотоор хүргэсэн. | 100% |
| 10.4 | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н журмыг батлуулна. | - | Захирлын тушаал | - | Төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллах | Төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/87 дугаар тушаалаар “Хөдөлмөрин аюулгүй байдал, эрүүл ахуйн журам”-ыг батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон аижллаж байна. | 100% |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | журмыг боловсруулан батлуулна. | | |
| 10.5 | Аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг хийнэ. | 78 Төсөл хөтөлбөр | -Хүргүүлсэн зөвлөмж<br>-Хэрэгжилтийн хувь | - | Аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийнэ | Цар тахлын сангийн буцалтгүй тусламжийн хүрээнд, НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан хэрэгжиж буй “Монгол улсын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг Нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бэхжүүлэх” төслийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дэмжлэгт хяналт хийх удирдамжийг боловсруулан батлуулсан. 2025 оны 6 дугаар сарын 8-ны өдрөөс 7 дугаар сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд Завхан, Хэнтий, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Увс, Ховд, Хөвсгөл, Баян-Өлгий, Өмнөговь, Дундговь, Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвүүд, Багануур дүүргийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн үйл ажиллагаанд тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үйл ажиллагаанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, чанар сайжруулах арга хэрэгслийн хэрэгжилт, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийн бүтэц, үйл ажиллагаа чиглэлээр дэмжлэгт хяналт хийсэн.<br>Хяналт хийсэн үр дүнгээр нийт 1105 оноо авахаас 704 оноо авч дундаж үзүүлэлт 63,7% байна. Дүгнэлтийг үндэслэн нийслэл, аймгийн ЗӨСТ-үүд тус бүрт зөвлөмж хүргүүлсэн. | 100% |

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах бодлогын бичиг баримтуудад тусгагдсан өөрийн төвийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээг тусгасан болно. Үүнд:

- “Алсын хараа-2050”
- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (ЗГҮАХ-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр)

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| • Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (МУТЖҮЧ-Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл)<br>• Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө<br>• Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө. 2024 онд болон 2025 онд тусгагдсан арга хэмжээ<br>• Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн стратеги 2024-2027 оны төлөвлөгөө | | | | | | | |
| 2025 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 57 арга хэмжээ төлөвлөсөн. Үүнд:<br>• Шинээр төлөвлөсөн 13 ажил<br>• 2024 оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 11 ажил<br>• Тогтмол зохион байгуулдаг 33 ажил | | | | | | | |

Зоонозын халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 2025 онд Засгийн газрын хөтөлбөрүүд, эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичигтэй уялдуулан 10 бүлэг 57 зорилтод үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажилласнаас гүйцэтгэлийн хэрэгжилт 96,4 хувьтай үнэлэн тайланг хүргүүлж байна.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ БИЕЛЭЛТ**

/ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ/

**2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр**

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхижүүлэх** | | | | | | |
| 1 | Засгийн газар төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1 | Нийт сургалт семинар, зөвлөгөөний тоо: | 32 | 31 | - Монгол улсын хэмжээнд зоонозын тэргүүлэх өвчний жагсаалтыг тодорхойлох хэлэлцүүлгийг 2025 оны 04 сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд Ховд, Увс, Говь-Алтай, Баян-Өлгий, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, Сэлэнгэ, Завхан, Дундговь, Өмнөговь аймаг, Нийслэлийн зоонозын өвчин судлалын төв, Зоонозын өвчин судлалын Үндэсний төвийн эмч, ажилтан 117 оролцож, дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.<br>- “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ сэдэвт дадлага сургуулилт зохион байгуулж, ЭМЯ, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн банк, МУЗН, Нийслэлийн ЭМГ, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Налайх дүүргийн ЭМТ, Багануур дүүргийн ЭМТ, Баянзүрх дүүргийн ЭМТ, Чингэлтэй дүүргийн ЭМТ, Сүхбаатар дүүргийн ЭМТ, Хан-Уул дүүргийн ЭМТ, Баянгол дүүргийн ЭМТ, СХДЭМТ, Багахангай ЭМТ, ХУДНЭ, Хүүхдийн төв сувилал, Хавдар судлалын үндэсний төв, ЦССҮТ, Эрүүл мэндийн хөгжлийн төв, СЭМҮТ, Геронтологийн үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, НЭМҮТ, УНТЭ, ХӨСҮТ, УХТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ, ЦТЭ, 14 |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт /тасралтгүй сургалт/ | 21 | 19 | |
| | | | Мэргэшүүлэх сургалт /үндсэн болон төрөлжсөн/ | 2 | 3 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ /Дагалдан сургалт/ | 6 | 6 | |
| | | | Бусад | 3 | 5 | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчды тоо: | 370 | 260 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 259 | 177 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 111 | 83 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 28 | 23 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 342 | 237 | |
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтанд хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | 95% | 90% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЗӨСТ, Сэлэнгэ, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Хэнтий, Завхан, Төв, Баян-Өлгий, Дундговь, Дархан-Уул, Архангай, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь, Ховд, Говьсүмбэр, Сүхбаатар, Увс зэрэг 50 байгууллагын 295 гаруй мэргэжилтэн оролцлоо.<br>- “Газарзүйн мэдээллийн системийн QGIS программ”-ийн дунд болон ахисан шатны онол, дадлага хосолсон 40 цагийн сургалтад ЗӨСҮТ болон орон нутгийн ЗӨСТөвүүдийн нийт 22 мэргэжилтэн амжилттай суралцлаа.<br>- 2025 оны 08 дугаар сарын 06–07-ны өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төвтэй хамтран MNS ISO/IEC 17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах шаардлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад тус төвийн болон Нийслэл, аймгийн 14 ЗӨСТ-ийн 60 эмч, мэргэжилтэн хамрагдаж сертификат олгосон.<br>- Ажлын байрны тасралтгүй сургалтын төлөвлөгөөний дагуу 14 удаа, нэмэлтээр 5 удаа нийт 19 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 180 мэргэжилтэн хамрагдсан.<br>- Мэргэшүүл сургалт буюу үндсэн мэргэшлийн сургалтыг 1 удаа, төрөлжсөн мэргэшлийн сургалтыг 2 удаа зохион байгуулсан.<br>- Ажлын байрны дагалдан сургалтыг 4 удаа зохион байгуулж 18 мэргэжилтэнг хамруулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Биологичийн мэргэшил олгох сургалтыг 1 удаа зохион байгуулж 8 биологчийг хамруулсан. |
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 11 | 8 | Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 35 мэргэжилтэн ОХУ, БНХАУ, Япон, Вьетнам, Малайз, Австрали, Пакистан, Тайланд зэрэг 8 улсад урт, богино хугацааны онол дадлагын сургалт, хурал,зөвлөгөөнд оролцсон байна. |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 23 | 35 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 16 | 23 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 7 | 12 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 2 | 4 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 25 | 31 | |
| | | 2.3 | Гадаад сургалтад хамруулсан байдал: нийт албан хаагчдад эзлэх хувь | 30% | 35% | – Япон улсын Хоккайдогийн Их сургуулийн Мал эмнэлгийн факултет, Обихирогийн ХАА, Мал эмнэлгийн сургуульд ЗӨСҮТ-ийн 3 мэргэжилтэн 2-3 сарын сургалтанд Зоонозын өвчний лабораторийн оношилгооны чадавхийг бэхжүүлэх, тандалт, судалгааны чиглэлээр дадлагажлаа.<br>– Австрали улсын Питер Доэртигийн нэрэмжит хүрээлэн, Малайз улсын эрүүл мэндийн үндэсний хүрээлэн, АУ-ны судалгааны хүрээлэн, Япон улсын Хоккайдо их сургууль, ОХУ-ын Эрхүү хотод 10 хоногийн онол, практикийн сургалтанд 14 мэргэжилтэн хамрагдав.<br>– Цөмийн энергийн атомын комиссын RAS5100 төслийн хүрээнд 2 удаагийн сургалт нь “Дамжуулагчаар дамжих өвчин болон дамжуулагчыг хянахад газарзүйн программыг хэрэглэх нь”, Дамжуулагчаар дамжих өвчин болон дамжуулагчыг түүвэрлэх, ялгах, илрүүлэх” сэдвээр Вьетнам улс, Пакистан улсын Пайзалабад хотод болж, ЗӨСҮТ-ийн 2 мэргэжилтэнд хамрагдлаа.<br>– ОХУ-ын Кронстадт хотод НЭМ-ын ноцтой байдлын үед авах эрүүл ахуй, тархвар судлалын арга хэмжээ сэдэвт хурал, зөвлөгөөн, Тайланд улсад “Ази, Номхон далайн бүс нутагт нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулахын тулд AMU/AMR өгөгдлийг тайлбарлах бүсийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | | | | | | сургалт"-нд ЗӨСҮТ-ийн 3 мэргэжилтэн хамрагдлаа.<br>– БНХМАУ, МУ-ын "Боомтын мэрэгч амьтны хил дамжих тархах зоонозын халдварт өвчний хамтарсан тандалт судалгааг зохион байгуулах" ажлын уулзалтанд ЗӨСҮТ-ийн 10 мэргэжилтэн оролцлоо. |
| 3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1 | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая.төг/ | 1,942,200 | 2,000,000 | Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд 2025 онд Нийслэлийн цагдаагийн газраас зохион байгуулсан "Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, хадгалах аюулгүй ажиллагааны сургалт"-д байгууллагын 6 ажилтанг хамруулж сургасан. |
| | | 3.2 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | 9% | Энэ онд ажилтны санаачлагаар хөдөлмөрийн гэрээ цуцалсан 6, орон тоог цөөрүүлсний улмаас хөдөлмөрийн гэрээ цуцалсан 2, шилжин ажилласан 1 нийт 9 ажилтан шилжилт хөдөлгөөнд орсон байна. |
| **Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах** | | | | | | |
| 4 | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хөгжүүлэх | 4.1 | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | | | Үндсэн цалинг ЗГ-ын 2024 оны 12 сарын 25 өдрийн 238 дугаар тогтоолоор, Урамшуулал болон нэмэгдэл хөлсийг ЗГ-ын 2018 оны 382 тоот тогтоол болон Төвийн захирлын А/38 дагуу сар бүр олгож байна.<br>Цалин, хөлс болон нэмэгдэл урамуулал нь нийт төсвийн 71 хувийг эзэлж үүнээс:<br>Үндсэн цалин- 36%<br>Нэмэгдэл- 22%<br>Унаа хоолны хөнгөлөлт- 6%<br>Урамшуулал- 4% байна. |
| | | 4.2 | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл /мян.төг/ | 5,500₮ | 15,000₮ | ЗГ-ын 2019 оны 6 тоот тогтоол, хөдөлмөрийн тухай хуул, байгууллага болон үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтыг гэрээг үндэслэн сар бүр олгож байна |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Албан хаагдчын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1 | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн /Албан хаагчдын сэтгэл ханамж/ | 60%+ | 62,0 % | Байгууллагын ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг албан хаагчдаас санал авч, өгсөн саналын дагуу асуумжийг шинэчлэн боловсруулж Захиргааны албаны даргаар батлуулан 8 бүлэгтэй 37 асуумжаар Google Forms программ ашиглан сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч дүнг нэгтгэн удирдлагын зөвлөлд танилцуулдаг. Албан хаагчдын судалгаанд хамрагдалтын дундаж хувь 1-р улиралд 71,1 хувь, 2-р улиралд 51 хувь, 3-р улирал 64%-тай байсан. Улирал бүрийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор "Сэтгэл ханамжаас бүтээмжид" жилийн төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| 6 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг /Жилд/ | 1 | 1 | Байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгийг улсын хоёр дугаар төв эмнэлгийн дэмжих төв болон Рехамед эмнэлэгтэй хамтран зохион байгуулж хамрагдвал зохих 89 албан хаагчаас нийт 84 албан хаагч буюу 94 хувь нь хамрагдсан. 5 албан хаагч тухайн жилд өөр эмнэлэгт оношилгоо шинжилгээнд хамрагдсан байна. Энэ удаагийн оношлогоо шинжилгээнд 2024 оны урьдчилан сэргийлэх үзлэгийн зарим зүйлд үндэслэн<br> 5 Төрлийн хавдрын маркер (Ходоод, элэг , бүдүүн шулуун гэдэс, түрүү булчирхай, өндгөвч)<br> Хөхний маммографи<br> Амьсгалаар хеликобактер илрүүлэх<br> Цээжний рентген зэрэгт хамруулан ажиллаж байна. Үүнээс :<br> Элэгний хавдрын маркер бага зэрэг өөрчлөлттэй /3/- 3,5%<br> Ходоодны хавдрын маркер бага зэрэг өөрчлөлттэй /1/-1,1%<br> өндгөвч хавдрын маркер бага зэрэг өөрчлөлттэй /1/- 1,1% |
| | | 6.2 | Албан хаагчдын хамрагдалт | 90%+ | 92% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | | | | | |  Амьсгалын сорилоор Hp илрүүлэх шинжилгээнд 37 албан хаагч хамрагдсанаас -32% халдваржилтгүй 68% халдваржилттай гарсан<br> Хөхний маммографид -37 эмэгтэй хамрагдсанаас /3/-8% хөхний эмчийн зөвлөгөө шаарлагатай<br> Архаг бронхит -34%<br> Уушгины эмчийн зөвлөгөө шаардлагтай /3 /- 3,5%<br> Үзлэг дүгнэлтийг үндэслэн хүн бүрд тохирсон зөвлөгөө зөвлөмж өгч дараагийн шатлалд үзүүлэх, эрүүлжүүлэх ,хуваарь гарган ажиллаж байна |
| 7 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1 | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ /сая.төг/ | 350,000 | 350,000 | Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3 дахь заалт, Төвийн дүрмийн 7 дугаар бүлгийн 7.2.1 дэх заалт, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний 3 дугаар бүлгийн 3.12 дахь заалтуудыг үндэслэн төвийн 2 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. |

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ